

УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ. ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА *Б.Б.* Б.БЭЛГҮТЭЙ  
*2022* оны 09-р сарын 01.-ны өдөр

МОНГОЛЫН  
ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО  
ШТТ8589 1009249 5220051162

**МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБООНЫ  
САЛБАР НЭГЖИЙН ХУРАЛ, ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УДИРДАМЖ**

**1. Нэг. Зорилго:**

Энэхүү удирдамжийн зорилго нь Монголын Залуучуудын Холбооны /МЗХ/ салбар нэгжүүдийн үйл ажиллагааг шинэчлэх, өөрчлөн байгуулах, сэргээн сайжруулах, эрчимжүүлэх зорилтын хүрээнд бүтцийн бүх шатны салбар нэгжийн ээлжит болон зэлжит бус чуулган, бага чуулган, хурлуудыг амжилттай зохион байгуулж, тухайн салбар нэгж, холбоодын удирдлага, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг үндсэн дүрмийн хүрээнд явуулж нийгэмд залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэн, тэдгээрийн санал санаачилгыг бодитоор дэмжиж залуусын эв нэгдэл, үйл ажиллагааны уялдааг сайжруулахад оршино.

**2. Хоёр. Баримт бичгүүд:**

- 2.1. Монголын Залуучуудын Холбооны Үндсэн дүрэм
- 2.2. МЗХ-ны бүтцийн бүх шатны байгууллагын Дотоод сонгуулийн журам
- 2.3. МЗХ-ны Хурал, Чуулганы үйл ажиллагааг зохион байгуулах дэгийн тухай журам
- 2.4. Тухайн салбарын батлагдсан дүрэм, журам эсхүл жишиг журам
- 2.5. МЗХ-ны татварын журам зэргийг баримтлан ажиллана.

**3. Гурав. Чуулганы өмнөх бэлтгэл ажил**

- 3.1. Хурал, чуулган зохион байгуулах ажлын хэсэг байгуулах,
  - 3.1.1 Гүйцэтгэх хорооноос ажлын хэсэг томилох эсхүл Тухайн салбар нэгжийн тэргүүлэгчдийн хурлаас ажлын хэсэг байгуулагдана.
- 3.2. Ажлын хэсгээс мандатын комисс байгуулж батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөөлөгчдөд Мандат олгох,
  - 3.2.1 Мандатын комисст тухайн салбар нэгжийн хяналтын зөвлөлийн төлөөллийг оролцуулна.
- 3.3. Хурал, чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтыг бэлтгэн Гүйцэтгэх хороогоор батлуулах,
- 3.4. Тухайн орон нутаг, байгууллагуудын удирдлагуудтай байгуулах хамтын ажиллагааны санамж бичигт шаардлагатай бодлого, үйл ажиллагааны төслийг бэлтгэж илгээх,
- 3.5. Тухайн орон нутгийн цагдаагийн газартай хамтран ажиллах санал хүргүүлэх
- 3.6. Чуулганы үйл ажиллагаанд шаардлагатай зүйлсийг бэлтгэх,
  - 3.6.1. Техник, тоног төхөөрөмжүүдийг бэлтгэх,
  - 3.6.2. Туг, далбаа, энгэрийн тэмдэг, шагнал, сэтгүүл сонингийн захиалгын тоог илгээх,
  - 3.6.3. Чуулганы үйл ажиллагаанд хэрэглэх дэвтэр, балыг бэлтгэх,
  - 3.6.4. Салбар нэгжийн бүрэлдэхүүнээс зайлшгүй нөхцөлд шагнаж урамшуулах шаардлагатай хүмүүсийн нэрсийг илгээх,
4. Дөрөв. Чуулганы төлөөлөгчдийн ирц
- 4.1. Ээлжит чуулганы төлөөлөгчдийн тоо нь Бага чуулганы гишүүдийн тооноос олон байна. Төлөөлөгчдийн тоог тухайн салбар нэгжийн Тэргүүлэгчдийн хурал эсхүл Бага чуулганаас тогтооно.
- 4.2. Ээлжит бус чуулганы төлөөлөгчдийн тоог тухайн салбар нэгжийн Тэргүүлэгчдийн хурлаас тогтоох ба Бага чуулганы гишүүдийн ердийн олонхиос илүү байна.

- 4.3. Бага чуулганы гишүүдийн тоо нь МЗХ-ны үндсэн дүрмэнд зааснаар 119 байх бөгөөд ердийн олонхи бүрдсэнээр ирц хүрсэнд тооцно.
- 4.4. Сум, хорооны залуучуудын холбооны хурал 29-өөс доошгүй төлөөлөгчтэй байна.
- 4.5. Баг, хэсэг, байгууллагын залуучуудын зөвлөлийн хурал 19-өөс доошгүй төлөөлөгчтэй байна.
- 4.6. Чиглэлийн залуучуудын холбооны чуулганы ирцийг тухайн салбар нэгжийн Тэргүүлэгчдийн хурлаас тогтоох бөгөөд 59-өөс доошгүй төлөөлөгчтэй байна.

## **5. Тав. Чуулганы үйл ажиллагаа**

### 5.1. Нээлт

5.1.1 МЗХ-ны удирдлагууд, Төр засгийн байгууллагын төлөөлөл, Хүндэт зочид

5.2. Хурал, Чуулганы төлөөлөгчдийг батламжах,

5.2.1 Мандатын комиссын илтгэлийн дагуу МЗХ-ны Хяналтын зөвлөлөөс чуулганы төлөөлөгчдийг батламжилж, Төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар саналын эрхийг баталгаажуулах, (Хяналтын зөвлөлийн ажиллах журам, Татварын журам, тэргүүлэгчдийн хурлын тогтоол болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.)

5.3. Хурал, Чуулганы дарга, тэргүүлэгчдийг сонгох

5.3.1 МЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга хурал, чуулганыг шууд даргалах эрхтэй. Энэ тохиолдолд хурлын тэргүүлэгчдийг ЕНБД санал болгоно.

5.3.2 Хурлын тэргүүлэгчид 3 ба түүнээс дээш байх ба шууд хурал даргалах эрхтэй албан тушаалтан байхгүй тохиолдолд төлөөлөгчдөөс хурлын тэргүүлэгчдийг ил санал хураалтаар, нээлттэй сонгоно.

5.4. Хурал, Чуулганы дэг батлах

5.4.1 МЗХ-ны Хурал, Чуулганы үйл ажиллагааг зохион байгуулах дэгийн тухай журмыг мөрдлөг болгоно.

Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр хурлын дэгийг батлана.

5.5. Тооллогын комиссыг сонгох, батлах,

5.6. Редакцийн комиссыг сонгох, батлах,

5.7. Салбар нэгжийн үйл ажиллагааны тайланг сонсох, хэлэлцэх, дүгнэлт өгөх,

5.8. Хяналтын зөвлөлийн тайлан илтгэлийг сонсох, дүгнэлт өгөх,

5.9. Салбарын дүрэм, журмыг хэлэлцэх, өөрчлөлт оруулах,

5.10. Тэргүүнийг сонгох, чөлөөлөх,

5.11. Тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх,

5.12. Хяналтын зөвлөлийг сонгох, чөлөөлөх,

5.12.1. Хяналтын зөвлөл гишүүд хяналтын зөвлөлийн даргыг сонгож, танилцуулах,

5.13. Бусад тогтоолын төслүүдийг хэлэлцэж батлах,

5.14. Сургалт,

5.15. Хэлэлцүүлэг,

5.16. Хаалт



*Хавсралтаар. Хурал, чуулганы тогтоолын төслүүдийг батлав.*